



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2020 оны 11 сарын 19 өдөр

Дугаар А/507

Арвайхээр

Хөрөнгө зарцуулах тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.6-ын "а", Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1 дэх заалт, Монгол Улсын Засгийн газрын 2020 оны "Бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн хугацааг сунгах тухай" 181 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Коронавирус (COVID-19) цар тахлын өвчлөлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор орон нутгийн зорчигч тээвэр, аймаг, сум хоорондох хувийн тээврийн хэрэгслийн зорчих хөдөлгөөнийг түр зогсоосонтой холбогдуулан хот хоорондын авто тээврийн шалган нэвтрүүлэх товчоо, Арвайхээр сумын хэмжээнд хяналтын постод үүрэг гүйцэтгэхэд шаардагдах зардлын тооцоог хавсралтаар баталсугай.

2.Аймгийн Онцгой комиссын шуурхай штаб, хяналтын постод ажиллах алба хаагчдын ариутгал, халваргүйжүүлэлт, бичиг хэрэг, хоол хүнс, шатахууны зардалд зарцуулах 16,847,000 (Арван зургаан сая найман зуун дөчин долоон мянга) төгрөгийг Гамшгаас хамгаалах, эрсдэлийг бууруулах арга хэмжээний зардлаас гаргахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэс (Д.Нэмэхбаяр)-т зөвшөөрсүгэй.

3.Хөрөнгийн зарцуулалтад хяналт тавьж, үр дүнг тооцож ажиллахыг аймгийн Онцгой байдлын газар (дэд хурандаа Д.Одонбаяр)-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



А.ИШДОРЖ

011101129

Аймгийн Засаг даргын 2020 оны 11...
дүгээр сарын 11...-ны өдрийн 1507
дугаар захирамжийн хавсралт



БҮХ НИЙТИЙН БЭЛЭН БАЙДЛЫН ЗЭРЭГТ ШИЛЖИХ ХҮРЭЭНД
ШУУРХАЙ ШТАБ, ХЯНАЛТЫН ПОСТОД ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭХ АЛБА
ХААГЧДЫН ХООЛ ХҮНС, ШАТАХУУНЫ ЗАРДЛЫН ТООЦОО

1. Штабад хэрэглэгдэх зардал

д/д	Материалын нэр	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгж үнэ	Нийт үнэ
1	Бичгийн цаас	боодол	14	12,000	168,000
2	Принтерийн хор	ширхэг	2	65,000	130,000
3	Өнгөт принтерийн хор	ширхэг	12	8,000	96,000
Нийт дүн					394,000

2. Шатахууны зардал

Д/д	Зарцуулагдах төрөл		Шатахууны төрөл	Нэг бүрийн үнэ	Литр	Нийт үнэ
1		Цахилгаан үүсгүүр	АИ-92	1400	1568	2,195,200
			Масло	9800	20	196,000
2	Онцгой байдлын газар	Постод үүрэг гүйцэтгэх автомашин	АИ-92	1400	3920	5,488,000
5		Постуудад хяналт шалгалт хийх	АИ-92	1 400	560	784,000
6		Урьдчилан сэргийлэх ажил	Аи-92	1400	840	1,176,000
7		Хөдөлгөөнт эргүүл хийх	Аи-92	1400	1680	2,352,000
8	Цагдаагийн газар	Урьдчилан сэргийлэх ажлаар явах	Аи-92	1400	280	392,000
9		Ёс журмын эргүүл хийх	Аи-92	1400	280	392,000
Дүн						12,975,000

3. Түлээ, нүүрс

Д/д	Материалын нэр	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэг бүрийн үнэ	Нийт дүн
1	Мод	шуудай	30	8000	240,000
Дүн					240,000

2.

4. Хамгаалах хэрэгсэл, бусад

Д/д	Материалын нэр	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэг бүрийн үнэ	Нийт дүн
1	Халуун хэмжигч	ш	10	70,000	700,000
2	Дохиур, шүгэл	ш	14	18,000	252,000
3	Санитол	ш	14	22,000	308,000
4	Резинэн бээлий	хайрцаг	50	25,000	1,250,000
5	Цэвэрлэгээний материал	ком	14	25,000	350,000
6	Жавелин	хайрцаг	7	54,000	378,000
Дүн					3,238,000
Нийт дүн					16,847,000

-oOo-